| 510030 | Ядуурлыг бууруулах зөвлөл |
| 510031 | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн олон талт хамтын ажиллагаа |
| 510040 | Тэтгэврийн нөхөн олговор |
| 510041 | Цэргийн байгууллагад ажиллаж байсан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл |
| 510050 | Төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын хураамж |
| 510060 | Ахмад настны үндэсний хөтөлбөр |
| 510061 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр |
| 510062 | Хүүхэд хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр |
| 510063 | Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр |
| 510064 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр |
| 510065 | Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр |
| 510066 | Хүн худалдаалахаас хамгаалах үндэсний хөтөлбөр |
| 511012 | Хүүхдийн оролцооны тухай нийгмийн ойлголтыг гүнзгийрүүлэх сургалт, сурталчилгаа |
| 520000 | Нийгмийн тодорхой бүлгүүдэд чиглэсэн арга хэмжээ |
| 520010 | Хүүхдийн төлөө сан |
| 520012 | Хүүхдийн парламентын үндэсний болон бүсийн чуулганыг зохион байгуулах |
| 900000 | Албан ёсны статистик, тооллого, судалгаа |
| 900001 | Макро эдийн засгийн статистик |
| 900002 | Хүн ам, нийгмийн статистик |
| 900003 | Эдийн засгийн статистик |
| 900010 | Хүн амын тооллого |
| 900013 | Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого |
| 900015 | Мал, тэжээвэр амьтдын тооллого |
| 900030 | Өрхийн орлого, зарлагын судалгаа |
| 900031 | Ажиллах хүчний судалгаа |
| 900032 | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа |
| 900033 | Орон сууцны үнийн индексийн судалгаа |
| 900034 | Хэрэглээний үнийн индексийн судалгаа |
| 900035 | Барилгын салбарын үнийн индексийн судалгаа |
| 900036 | Хүнсний хангамж, аюулгүй байдал статистик үзүүлэлтийг бий болгох судалгаа |

| | |
|---|---|
| 900037 | Жижиглэнгийн үнийн мэдээлэл цуглуулах судалгаа |
| 900038 | Аж ахуйн салбарын үнийн судалгаа |
| 900039 | Нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийн судалгаа |
| 900040 | Малын ашиг шим хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гарцын судалгаа |
| 900041 | Ардчилсан засаглалын судалгаа |
| 900042 | Албан ёсны статистик хөгжүүлэх хөтөлбөр |
| 900043 | Бюллетень танилцуулгын эмхэтгэл |
| 900044 | Завсрын хэрэглээний судалгаа |
| 900045 | Барилгын тоног төхөөрөмжийн үнийн судалгаа |
| 900046 | Тариалсан талбайн га-гийн ургацын судалгаа |
| 900047 | Хүүхэд хөгжлийн судалгаа |
| 900048 | Цаг ашиглалтын судалгаа |
| 900049 | Цогц судалгаа |
| 900050 | Тооллогын нэгжийн зураглал хийх |
| 900051 | Тооллогын асуулгын хуудас боловсруулах, маягт заавар хэвлүүлэх |
| 900052 | Тооллогын мэдээлэл боловсруулах |
| 900053 | Тооллогын үр дүнг хэвлүүлэх, тараах |
| 910000 | Эрдэм шинжилгээний ажил |
| 920000 | Олон салбарыг хамарсан хөгжлийн хөтөлбөр |
| 920001 | Эдийн засгийн бодлого, стратеги судалгааны ажил |
| 930000 | Олон нийтийн болон төрийн бус байгууллагад олгох дэмжлэг |
| 930010 | Үндэсний олон нийтийн радио, телевизэд олгох дэмжлэг |

**Засгийн газрын 2009 оны 99 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт**

## ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН АНГИЛАЛ

| № | А. Улсын төсөв |
|---|---|
| 1 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга |
| 2 | Монгол Улсын Их Хурлын дарга |
| 3 | Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга |
| 4 | Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч |
| 5 | Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга |
| 6 | Улсын ерөнхий прокурор |
| 7 | Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн нарийн бичгийн дарга |
| 8 | Монгол Улсын Ерөнхий сайд |
| 9 | Монгол Улсын Тэргүүн шадар сайд |
| 10 | Монгол Улсын Шадар сайд |
| 11 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 12 | Хууль зүй, дотоод хэргийн сайд |
| 13 | Сангийн сайд |
| 14 | Гадаад харилцааны сайд |
| 15 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд |
| 16 | Батлан хамгаалахын сайд |
| 17 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд |
| 18 | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд |
| 19 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд |
| 20 | Эрүүл мэндийн сайд |
| 21 | Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд |
| 22 | Эрдэс баялаг, эрчим хүчний сайд |

| | |
|---|---|
| 23 | Үндэсний ерөнхий аудитор |
| 24 | Үндэсний статистикийн газрын дарга |
| 25 | Санхүүгийн зохицуулах хорооны дарга |
| 26 | Төрийн албаны зөвлөлийн дарга |
| 27 | Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга |
| 28 | Сонгуулийн ерөнхий хорооны дарга |
| 29 | Хүний эрхийн Үндэсний комиссын дарга |
| 30 | Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн захирал |
| 31 | Авлигатай тэмцэх газрын дарга |
| | Б.Орон нутгийн төсөв |
| 1 | Архангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 2 | Архангай аймгийн Засаг дарга |
| 3 | Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 4 | Баян-Өлгий аймгийн Засаг дарга |
| 5 | Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 6 | Баянхонгор аймгийн Засаг дарга |
| 7 | Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 8 | Булган аймгийн Засаг дарга |
| 9 | Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 10 | Говь-Алтай аймгийн Засаг дарга |
| 11 | Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 12 | Дорноговь аймгийн Засаг дарга |
| 13 | Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 14 | Дорнод аймгийн Засаг дарга |
| 15 | Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 16 | Дундговь аймгийн Засаг дарга |
| 17 | Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 18 | Завхан аймгийн Засаг дарга |
| 19 | Өвөрхангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 20 | Өвөрхангай аймгийн Засаг дарга |
| 21 | Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 22 | Өмнөговь аймгийн Засаг дарга |
| 23 | Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 24 | Сүхбаатар аймгийн Засаг дарга |
| 25 | Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 26 | Сэлэнгэ аймгийн Засаг дарга |
| 27 | Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 28 | Төв аймгийн Засаг дарга |
| 29 | Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 30 | Увс аймгийн Засаг дарга |
| 31 | Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 32 | Ховд аймгийн Засаг дарга |
| 33 | Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 34 | Хөвсгөл аймгийн Засаг дарга |
| 35 | Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 36 | Хэнтий аймгийн Засаг дарга |
| 37 | Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 38 | Дархан-Уул аймгийн Засаг дарга |
| 39 | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 40 | Нийслэлийн Засаг дарга |
| 41 | Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 42 | Орхон аймгийн Засаг дарга |
| 43 | Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 44 | Говьсүмбэр аймгийн Засаг дарга |
| 45 | Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нар |
| 46 | Сум, дүүргийн Засаг дарга нар |

Засгийн газрын 2009 оны 99 дүгээр
тогтоолын 4 дүгээр хавсралт

## ТӨСВИЙН ОРЛОГЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ

| № | Ангилал |
|---|---|
| 1 | Нийт орлого болон тусламжийн дүн |
| 11 | Нийт орлого |
| 111 | Урсгал орлого |
| 1111 | Татварын орлого |
| 11111 | Орлогын албан татвар |
| 111111 | Хувь хүний орлогын албан татвар |
| 1111111 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын |
| 1111112 | Үйл ажиллагааны орлогын |
| 1111113 | Хөрөнгийн орлогын |
| 1111114 | Хөрөнгө борлуулсны орлогын |
| 1111115 | Малчин өрх, мал бүхий этгээдийн орлогын |
| 1111116 | Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого |
| 1111117 | Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал |
| 1111118 | Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого |
| 1111119 | Шууд бус орлого |
| 111112 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт |
| 111113 | Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар |
| 1111131 | Төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллага |
| 1111132 | Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага |
| 111114 | Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар |
| 11112 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого |
| 111121 | Тэтгэврийн даатгалын шимтгэл |
| 1111211 | Ажил олгогч аж ахуйн нэгжээс төлөх шимтгэл |
| 1111212 | Ажиллагсдаас төлөх шимтгэл |
| 1111213 | Төсөвт газраас төлөх шимтгэл |
| 1111214 | Нөхөн олговор авагсдын шимтгэл |
| 1111215 | Сайн дурын даатгуулагчаас төлөх |
| 111122 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл |
| 1111221 | Ажил олгогч аж ахуйн нэгжээс төлөх шимтгэл |
| 1111222 | Ажиллагсдаас төлөх шимтгэл |
| 1111223 | Төсөвт газраас төлөх шимтгэл |
| 1111224 | Нөхөн олговор авагсдын шимтгэл |
| 1111225 | Сайн дурын даатгуулагчаас төлөх |
| 111123 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэл |
| 1111231 | Ажил олгогч аж ахуйн нэгжээс төлөх шимтгэл |
| 1111232 | Ажиллагсдаас төлөх шимтгэл |
| 1111233 | Төсөвт газраас төлөх шимтгэл |
| 1111234 | Нөхөн олговор авагсдын шимтгэл |
| 1111235 | Сайн дурын даатгуулагчаас төлөх |
| 111124 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл |
| 1111241 | Ажил олгогч аж ахуйн нэгжээс төлөх шимтгэл |
| 1111242 | Ажиллагсдаас төлөх шимтгэл |
| 1111243 | Төсөвт газраас төлөх шимтгэл |

| | |
|---|---|
| 1111244 | Нөхөн олговор авагсдын шимтгэл |
| 1111245 | Сайн дурын даатгуулагчаас төлөх |
| 111125 | Эрүүл мэндийн даатгалын шимтгэл |
| 1111251 | Ажил олгогч аж ахуйн нэгжээс төлөх шимтгэл |
| 1111252 | Ажиллагсдаас төлөх шимтгэл |
| 1111253 | Төсөвт газраас төлөх шимтгэл |
| 1111254 | Нөхөн олговор авагсдын шимтгэл |
| 1111255 | Сайн дурын даатгуулагчаас төлөх |
| 11113 | Өмчийн татвар |
| 111131 | Үл хөдлөх хөрөнгийн татвар |
| 111132 | Өв залгамжлал, бэлэглэлийн татвар |
| 111133 | Санхүүгийн ба хөрөнгийн гүйлгээний татвар |
| 111134 | Бууны албан татвар |
| 111135 | Бусад нэг удаагийн татвар |
| 111136 | Бусад тогтмол ногдуулах татвар |
| 11114 | Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар |
| 111141 | Бараа, үйлчилгээний ерөнхий татвар |
| 1111411 | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| 11114111 | Дотоодын барааны НӨАТ |
| 11114112 | Импортын барааны НӨАТ |
| 11114113 | Алтны НӨАТ |
| 11114114 | НӨАТ-ын буцаан олголт |
| 1111412 | Худалдааны татвар |
| 1111413 | Гүйлгээний болон бараа, үйлчилгээний бусад татвар |
| 111142 | Онцгой албан татвар |
| 1111421 | Дотоодын архины |
| 1111422 | Дотоодын тамхины |
| 1111423 | Дотоодын пивоны |
| 1111424 | Импортын архи, тамхины |
| 1111425 | Импортын пивоны |
| 1111426 | Суудлын автомашины |
| 1111427 | Автобензин, дизель түлшний |
| 111143 | Тусгай зориулалтын орлого |
| 1111431 | Автобензин, дизель түлшний албан татвар |
| 1111432 | Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| 11115 | Гадаад үйл ажиллагааны орлого |
| 111151 | Импортын гаалийн албан татвар |
| 111152 | Экспортын гаалийн албан татвар |
| 11116 | Бусад татвар (төлбөр, хураамж) |
| 111161 | Улсын тэмдэгтийн хураамж |
| 111162 | Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр |
| 111163 | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр |
| 111164 | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр |
| 111165 | Газрын төлбөр |
| 111166 | Ойгоос түлээ, мод бэлтгэж ашигласны төлбөр |
| 111167 | Ан амьтан барих эдийн засгийн хураамж |
| 111168 | Бусад татвар, хураамж |
| 1111681 | Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашигласны төлбөр |
| 1111682 | Ус ашигласны төлбөр |
| 1111683 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр |
| 1111684 | Рашаан ашигласны төлбөр |
| 1111685 | Байгалийн ургамал ашигласны төлбөр |
| 1111686 | Бусад татвар, хураамж |
| 1112 | Татварын бус орлого |
| 11121 | Хувьцааны ногдол ашиг |
| 11122 | Хүү, торгуулийн орлого |
| 11123 | Төсөвт байгууллагын өөрийн орлого |
| 11124 | Түрээсийн орлого |
| 11125 | Газрын тосны орлого |
| 11126 | Навигацын орлого |
| 11127 | Монгол банкны ашиг |
| 11128 | Бусад орлого |
| 112 | Хөрөнгийн орлого |
| 1121 | Хөрөнгө борлуулсны орлого |
| 1122 | Өмч хувьчлалын орлого |
| 12 | Тусламжийн орлого |
| 121 | Гадаад улс орноос үзүүлэх тусламжийн орлого |
| 122 | Олон улсын байгууллагаас үзүүлэх тусламжийн орлого |
| 123 | Засгийн газрын бус дотоодын байгууллагаас үзүүлэх тусламжийн орлого |
| 124 | Төсөв хоорондын шилжүүлэг |

Засгийн газрын 2009 оны 99 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт

### ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХӨТӨЛБӨРИЙН АНГИЛАЛ

| № | Ангилал |
|---|---|
| 000000000000000 | Ангилагдаагүй үйл ажиллагаа |
| 001000000000000 | Нийтийн ерөнхий үйлчилгээ |
| 001001000000000 | Гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллага, Санхүү төсвийн агентлаг, гадаад асуудал эрхэлсэн байгууллага |
| 001001001000000 | Гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллага |
| 001001002000000 | Санхүү, төсвийн харилцаа |
| 001001003000000 | Гадаад харилцаа |
| 001003000000000 | Төрийн нийтлэг үйлчилгээ |
| 001003001000000 | Төрийн албаны нийтлэг үйл ажиллагаа |
| 001003002000000 | Статистикийн нийтлэг үйл ажиллагаа |
| 001003003000000 | Төрийн аудит, төрийн удирдлагын нийтлэг шинжтэй бусад хяналт |
| 001003004000000 | Сонгууль зохион байгуулах |
| 001003020000000 | Улсын бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаа |
| 001003025000000 | Стандартчилал, хэмжил зүй |
| 001003030000000 | Авлигатай тэмцэх үйл ажиллагаа |
| 001003031000000 | Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах |
| 001003033000000 | Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа |
| 001003035000000 | Төрийн тусгай хамгаалалт |
| 001003040000000 | Төр, засгийн үйлчилгээ |
| 001003041000000 | Төрийн тусгай үйлчилгээ |
| 002000000000000 | Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа |
| 002001000000000 | Гадаад орнуудад үзүүлэх эдийн засгийн тусламж |
| 002002000000000 | Засгийн газрын өрийн гүйлгээ |
| 002003000000000 | Засаг захиргааны түвшин хоорондын ерөнхий зориулалтын татаас |
| 002004000000000 | Тусгай сан, ангилагдаагүй нөөц |
| 003000000000000 | Батлан хамгаалах |
| 003001000000000 | Зэвсэгт хүчин |
| 003008000000000 | Иргэний хамгаалалт |
| 003009000000000 | Хил хамгаалах |
| 003010000000000 | Батлан хамгаалахын судалгаа, шинжилгээ |
| 003099000000000 | Гадаад улсад үзүүлэх цэргийн тусламж |
| 004000000000000 | Нийгмийн хэв журам, аюулгүй байдал |
| 004001000000000 | Шүүх |
| 004002000000000 | Прокурорын хяналт |
| 004003000000000 | Цагдаа |
| 004005000000000 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа |
| 004006000000000 | Үндэсний аюулгүй байдлыг хангах |
| 004007000000000 | Шүүхийн шинжилгээ |
| 004009000000000 | Гал |
| 004010000000000 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа |
| 004100000000000 | Эрх зүйн бодлогын төлөвлөлт, зохицуулалт |
| 004800000000000 | Нийгмийн хэв журмын судалгаа, шинжилгээ |
| 005000000000000 | Худалдаа, эдийн засаг, ажил эрхлэлтийн харилцаа |
| 005001000000000 | Худалдаа, эдийн засгийн харилцаа |
| 005002000000000 | Хөдөлмөр, ажил эрхлэлт |
| 006000000000000 | Хөдөө аж ахуй |
| 006001000000000 | Мал аж ахуй |
| 006002000000000 | Газар тариалан |

| | |
|---|---|
| 006003000000000 | Хүнс |
| 006010000000000 | ХАА-н бодлого боловсруулалт, удирдлага, зохицуулалт |
| 006030000000000 | ХАА-н эрдэм шинжилгээний ажил |
| 007000000000000 | Түлш, эрчим хүч |
| 007001000000000 | Эрчим хүч |
| 007002000000000 | Түлш |
| 007003000000000 | Нефть |
| 007004000000000 | Цөмийн эрчим хүч |
| 008000000000000 | Олборлолт, аж үйлдвэр болон барилга |
| 008001000000000 | Олборлолт, уул уурхай |
| 008002000000000 | Аж үйлдвэр |
| 008003000000000 | Барилга |
| 009000000000000 | Тээвэр |
| 009001000000000 | Зам, тээвэр |
| 009002000000000 | Усан тээвэр |
| 009003000000000 | Төмөр зам |
| 009004000000000 | Агаарын тээвэр |
| 009019000000000 | Дамжуулах хоолой болон бусад тээвэрлэлт |
| 009020000000000 | Авто тээврийн хяналт, зохицуулалт, нийтийн тээвэр |
| 010000000000000 | Харилцаа холбоо |
| 010001000000000 | Харилцаа холбооны зохицуулалт |
| 010010000000000 | Харилцаа холбооны олон улсын суваг ашиглах |
| 011000000000000 | Эдийн засгийн бусад салбар |
| 011001000000000 | Худалдааны сүлжээ, агуулах, хадгалалт |
| 011002000000000 | Ресторан, зочид буудал |
| 011003000000000 | Аялал жуулчлал |
| 011004000000000 | Олон салбар хамарсан хөгжлийн хөтөлбөр |
| 016000000000000 | Байгаль орчин |
| 016001000000000 | Хог хаягдал |
| 016002000000000 | Бохир ус, цэвэрлэх байгууламж |
| 016004000000000 | Биологийн төрөл зүйлийн хамгаалалт |
| 016005000000000 | Газар, газрын хэвлийг хамгаалах |
| 016006000000000 | Ойжуулалт |
| 016007000000000 | Усны нөөц, нуур, гол мөрний менежмент |
| 016008000000000 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт |
| 016018000000000 | Ус, цаг уур |
| 016020000000000 | Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол |
| 016030000000000 | Байгаль орчны ерөнхий бодлого, төлөвлөлт |
| 016035000000000 | Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналт |
| 016800000000000 | Байгаль орчны судалгаа, шинжилгээ |
| 017000000000000 | Барилга, орон сууц, хот байгуулалт, нийтийн аж ахуй |
| 017001000000000 | Орон сууц |
| 017002000000000 | Хот байгуулалт, тохижилт |
| 017003000000000 | Суурин газрын усан хангамж |
| 017006000000000 | Ариун цэврийн байгууламж |
| 017020000000000 | Барилга, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ |
| 018000000000000 | Эрүүл мэнд |
| 018001000000000 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ |
| 018002000000000 | Нөхөн сэргээх тусламж үйлчилгээ |
| 018003000000000 | Удаан хугацааны асаргаа, сувилгаа |
| 018004000000000 | Эрүүл мэндийн нэмэлт үйлчилгээ |
| 018006000000000 | Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа, засвар, тохируулга |
| 018007000000000 | Урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ |
| 018008000000000 | Эмнэлгийн удирдлага ба эрүүл мэндийн даатгал |

| | |
|---|---|
| 01801000000000 | Нийгмийн эрүүл мэнд |
| 01802000000000 | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ |
| 01900000000000 | Спорт, нийтийн биеийн тамир |
| 01900100000000 | Спортын уралдаанд бэлтгэх, оролцох үйл ажиллагаа |
| 01900200000000 | Нийтийн биеийн тамир |
| 02000000000000 | Соёл урлагийн хөтөлбөр |
| 02100000000000 | Хэвлэл мэдээллийн үйлчилгээ |
| 02100100000000 | Үндэсний олон нийтийн радио, телевиз |
| 02100200000000 | Төрийн байгууллагын хэвлэл мэдээллийн алба |
| 02100300000000 | Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа |
| 02200000000000 | Боловсрол |
| 02200100000000 | Сургуулийн өмнөх боловсрол |
| 02200200000000 | Ерөнхий боловсрол |
| 02200300000000 | Дээд боловсрол |
| 02200400000000 | Мэргэжлийн боловсрол |
| 02200500000000 | Бүх нийтийн боловсролын үйлчилгээ |
| 02200600000000 | Боловсрол олгох татаас |
| 02201000000000 | Төрийн тусгай албан хаагчдын мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ |
| 02203000000000 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарыг удирдлагаар хангах |
| 02300000000000 | Нийгмийн хамгаалал |
| 02300100000000 | Нийгмийн халамж |
| 02300200000000 | Нийгмийн даатгал |
| 02300300000000 | Нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр, арга хэмжээ |
| 02300700000000 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналт |
| 02300800000000 | Нийгмийн хамгааллын чиглэлийн эрдэм шинжилгээний ажил |
| 02400000000000 | Нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн олон нийтийн үйлчилгээ |
| 02400100000000 | Биеийн тамир, спорт |
| 02400500000000 | Хүүхдийн эрх, хамгаалал, хөгжил |
| 02401000000000 | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлын удирдан зохион байгуулалт |
| 02700000000000 | Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ |
| 02700300000000 | Эрдэм шинжилгээ, судалгааны ажил |
| 02700500000000 | Шинжлэх ухааны байгууллагуудын нийтлэг үйлчилгээ |

**Засгийн газрын 2009 оны 99 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт**

## ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ЗААВАР

2 Нийт зарлага болон цэвэр зээлийн дүн. Нийт зарлага болон эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн нийлбэр дүнтэй тэнцэнэ.

2 1 Нийт зарлагын дүн. Төр үйл ажиллагаа эрхлэн явуулж, чиг үүргээ хэрэгжүүлэхэд зарцуулагдах эргэн төлөгдөх нөхцөлгүй төлбөрийг зарлага гэнэ. Нийт зарлага нь урсгал зардал болон хөрөнгийн зардлын нийлбэр дүнгээс бүрдэнэ.

2 1 1 Урсгал зардлын дүн. Тухайн тайлант жилд үйл ажиллагаа эрхлэн явуулахад зарцуулагдах урсгал зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Урсгал зардал нь 1/ бараа, үйлчилгээний зардал, 2/ зээлийн үйлчилгээ, 3/ татаас ба урсгал шилжүүлэг гэсэн зардлаас бүрдэнэ.

2 1 1 1 Бараа, үйлчилгээний зардал. Төр өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулагдах урсгал зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Үүнд 1/ цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, 2/ ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл болон 3/ бараа, үйлчилгээний бусад зардлууд багтана.

2 1 1 1 1 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил. Ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар

нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд энэ ангилалд хамаарна.

2 1 1 1 1 01 Үндсэн цалин. Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана.

2 1 1 1 1 02 Нэмэгдэл цалин. Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалингууд, тухайлбал, онцгой нөхцөлийн, ажилласан хугацааны, зэрэг дэвийн, мэргэжлийн зэргийн, ур чадварын, дэвтэр зассан, анги удирдсан, цолны цалин гэх мэт үндсэн цалингаас хувиар бодож буюу үнэмлэхүй хэмжээгээр тогтоон олгож байгаа нэмэгдлүүд багтана.

2 1 1 1 1 03 Бүтцийн өөрчлөлт хийх цалингийн сан. Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд үндсэн цалингийн санд орох өөрчлөлтийг түр хугацаагаар бүртгэн, холбогдох тогтоол, шийдвэр гарсны дараа үндсэн цалингийн санд нэгтгэн засварлах зорилгоор энэ ангиллыг ашиглана.

2 1 1 1 1 04 Гэрээт ажлын цалин. Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу гэрээгээр ажиллагсдад олгож байгаа цалингийн дүнг энэ ангилалд бүртгэнэ.

2 1 1 1 1 05 Унаа, хоолны хөнгөлөлт. Ажлын үр дүнгээр үндсэн болон нэмэгдэл цалинд нэмэлтээр олгож байгаа унаа, хоолны хөнгөлөлтийн нэмэгдлийг энд бүртгэнэ.

2 1 1 1 1 05 Үр дүнгийн урамшуулал. Ажлын үр дүнгээр үндсэн болон нэмэгдэл цалинд нэмэлтээр олгож байгаа үр дүнгийн урамшууллыг энэ ангилалд бүртгэнэ

2 1 1 1 2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл. Ажил олгогчоос буюу төсөвт байгууллагаас тайлангийн хугацаанд Нийгмийн даатгалын болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр үндсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож энэ ангилалд бүртгэнэ.

2 1 1 1 2 01 Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл. Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу тодорхой хувь хэмжээгээр тооцон ажил олгогчоос төлөх тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг даатгалын төрлөөр ангилж энэ ангилалд бүртгэнэ.

2 1 1 1 2 02 Эрүүл мэндийн даатгалын хураамж. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу тодорхой хувь хэмжээгээр тооцон ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг даатгалын төрлөөр ангилж энэ ангилалд бүртгэнэ.

2 1 1 1 3 Бараа, үйлчилгээний бусад зардал. Төсөвт байгууллагын үйл ажиллагааг хангах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах бараа, ажил үйлчилгээг тухайн байгууллага худалдан авах хөрөнгийн бус зардал, төлбөр хураамжийг энэ ангилалд бүртгэнэ. Бараа, ажил үйлчилгээний бусад зардлыг дотор нь 1/ үндсэн үйл ажиллагааны зардал, 2/ арга хэмжээний чанартай зардал гэж хуваагж үзнэ.

2 1 1 1 3 01 Бичиг хэргийн зардал. Байгууллага хэвийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах бичгийн болон тооцоолон бодох, хэвлэх, олшруулах техник хэрэгсэлд шаардагдах тууз /хор/, бэх, бичгийн цаас, үдээс, хавчаар, үзэг, харандаа, албан хэргийн хавтас, албан бичгийн хэвлэмэл хуудас болон эдгээр зардалтай адилтгах бусад зардлуудыг энэ дансанд бүртгэнэ.

2 1 1 1 3 02 Гэрэл, цахилгааны зардал. Үйлчлэгч байгууллагатай байгуулсан гэрээ болон цахилгааны эрчим хүчийг хэмжих тоолуурын заалтын дагуу байгууллагын хэрэгцээнд ашигласан цахилгааны эрчим хүчний (гэрэл, цахилгаан) төлбөр, өөрийн эх үүсвэрээр цахилгааны эрчим хүчээр хангахад гарсан зардлыг харуулна.

2 1 1 1 3 03 Түлш, халаалтын зардал. Уурын болон дулааны халаалтад холбогдсон байгууллага үйлчлэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлөх дулааны эрчим хүч болон халуун усны төлбөр, мөн түүнчлэн ердийн халаалтын зууханд хэрэглэх аргал, түлээ, нүүрс, мод зэрэг түлшинд гарсан зардлыг харуулна. Мөн тухайн байгууллага өөрийн болон бусдын тээврээр түлш бэлтгэхтэй холбогдон гарах бензин, шатахууны зардал, тээврийн хөлсийг энэ зардалд хамааруулна.

2 1 1 1 3 04 Тээвэр, шатахууны зардал. Байгууллагын өөрийн авто тээврийн хэрэгсэлд зарцуулах шатах, тослох материал, бусдын тээврээр гэрээ байгуулсны үндсэн дээр ажил, үйлчилгээ гүйцэтгүүлсний хөлс зэрэгт гарсан зардлуудыг энэ ангилалд бүртгэнэ.

2 1 1 1 3 05 Шуудан, холбооны зардал. Цахилгаан, бичиг, захидал шуудангаар явуулах

зэрэг холбооны байгууллагаар үйлчлүүлэхэд гарсан зардлыг энэ ангилалд бүртгэнэ.

2 1 1 1 3 06 Цэвэр, бохир усны зардал. Байгууллагын дотоод хэрэгцээнд төвлөрсөн ба төвлөрсөн бус хангамжаас ашигласан цэвэр болон бохир усны төлбөрийг харуулна. Тухайн байгууллага цэвэр, бохир усыг өөрийн байгууллагын тээврээр зөөвөрлөж ашигладаг бол гарсан тээврийн зардлыг нь мөн энэ дансанд бүртгэнэ.

2 1 1 1 3 07 Хоолны зардал. Хууль тогтоомжийн дагуу төрөөс хүнсний бүтээгдэхүүн болон хоолоор хангах үйлчилгээтэй холбогдсон (тухайлбал, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн хоолны зардал, сургалт, үйлдвэрлэлийн төвүүд болон ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдийн дотуур байрны хоолны зардал, хугацаат цэргийн албан хаагч, сэжигтэн, хоригдлын хоолны зардал, хил дээр ажиллаж байгаа офицер, ахлагчийн хүнсний хангамжийн зардал гэх мэт) зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Энэ зардал нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой эрх бүхий байгууллагаас батлагдсан норм, нормативын дагуу төлөвлөгдөж, гүйцэтгэл нь тооцогддог бөгөөд төлөвлөгөө болон гүйцэтгэлийн хоолны зардлын нийт хэмжээ нь тухайн үйлчилгээг авсан хүний тоотой шууд уялдсан байна.

2 1 1 1 3 08 Эм, вакцины зардал. Хууль тогтоомжийн дагуу төрөөс хүн ам, иргэдийг эм, эмчилгээний үйлчилгээгээр хангах үүрэг хүлээсэн байгууллагын үйл ажиллагаатай холбогдон хүн, малын эмчилгээ, сувилгаанд хэрэглэгдэх эм, боох материал, Дархлаажуулалтын болон Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хуулийн дагуу урьдчилан сэргийлэх болон халдваргүйжүүлэлтийг хангах вакцин худалдан авах зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Энэ зардал нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой эрх бүхий байгууллагаас батлагдсан норм, нормативын дагуу төлөвлөгдөж, гүйцэтгэл нь тооцогддог. Эм болон вакцины зардлын хамрагдах хүн, малын тоотой хамааралтайгаар төлөвлөгдөх бөгөөд гүйцэтгэл ч энэ зарчмаар тооцогдох болно.

2 1 1 1 3 09 Байрны түрээсийн хөлс. Байгууллага үндсэн үйл ажиллагаагаа эрхлэн явуулахдаа бусдын өмчийн байр, орон сууцыг түрээсээр ашигладаг бол түрээсийн зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн түр хугацаагаар зохион байгуулахад ашигласан байрны түрээсийн төлбөрийг энд бүртгэхгүй, сургалт, семинар зохион байгуулах зардалд бүртгэнэ.

2 1 1 1 3 10 Холбооны суваг ашигласны хөлс. Телефон утас, факс, телекс, хот хоорондын яриа, интернет ашигласны төлбөр болон телевизийн болон мэдээллийн бусад байгууллага сансрын болон гадаад орны бусад агентлагуудын сувгийг ашигласны төлбөрийг төсвөөс төлөх бол энэ ангилалд бүртгэнэ.

2 1 1 1 3 11 Албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал. Төсөвт байгууллагын өөрийн удирдлага болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийн дагуу тусгайлсан удирдамж, программаар гадаад, дотоодод албан томилолтоор ажиллахад гарах тээврийн зардал, байрны болон хоолны зардал, томилолтоор ажиллахтай холбогдсон бэлэг дурсгал зэрэг бусад зардал, мөн гадаадын албан төлөөлөгчийг хүлээн авах, байршуулахтай холбогдсон зардлыг энэ дансанд бүртгэнэ. Дотоод ба гадаад албан томилолтын болон гадаадын зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг тус тусад нь төлөвлөж, гүйцэтгэлийг гаргана.

2 1 1 1 3 12 Ном, хэвлэл авах. Байгууллагын албан ажлын хэрэгцээний зориулалтаар ашиглах дотоод, гадаадын тогтмол хэвлэл захиалахад гарсан зардлыг энэ дансанд бүртгэнэ. Номын сангийн номын фондыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байгууллага номын сангийн номыг нэмэгдүүлэх буюу шинэчлэх чиглэлээр авсан номыг энэ дансанд бүртгэхгүй, харин хөрөнгийн холбогдох дансанд бүртгэнэ.

2 1 1 1 3 13 Хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт. Бүх шатны боловсролын байгууллагуудын үзүүлэн таниулах материал, хичээлийн ба лабораторийн багаж, бодис худалдан авах, сургуулиудын хичээлийн байрандаа буюу хичээлийн байрнаас гадагш явж дадлага хийхтэй холбогдсон зардлыг энэ ангилалд бүртгэнэ.

2 1 1 1 3 14 Эд хогшил худалдан авах зардал. Байгууллагын аж ахуйн үйл ажиллагааны зориулалтаар ашиглах (албан байрны тохижилт, цэвэрлэгээ болон аж ахуйн хэрэгцээний зориулалтаар худалдан авсан материал, эд зүйлс, цаг уурын судалгаанд шаардагдах бөмбөлөг, цаг агаарын дулаан, хүйтний хэм хэмжигч гэх мэт) бага үнэтэй буюу түргэн элэгдэх эд зүйлсийг худалдан

авч шууд зарлагадах үед гарсан зардлыг бүртгэнэ. Эд хогшил худалдан авах зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг 1/ багаж хэрэгсэл, 2/ тавилга, 3/ хөдөлмөр хамгааллын хэрэглэл, 4/ бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс (аж ахуйн цэвэрлэгээний бодис, хэрэглэлийн зардлыг энд хамруулна), 5/ программ хангамжийн зардал тус бүрээр гаргана.

2 1 1 1 3 15 Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл. Хуулийн дагуу тусгай дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий албан хаагчдын дүрэмт хувцас болон ажлын тусгай зориулалтын нормын хувцас худалдан авах, түүнийг хийлгэхтэй холбогдсон үндсэн, туслах материал болон бусад зардал, эмнэлэг, сургуулийн дотуур байр, цэргийн болон бусад төсөвт байгууллагын хэрэгцээнд ашиглах ор, дэрний хэрэгсэл болон бусад зөөлөн эдлэлийг бүртгэнэ.

2 1 1 1 3 16 Урсгал засвар. Байгууллага өөрийн үндсэн хөрөнгө /орон байр, тавилга хэрэгсэл, ердийн хөсөг, авто тээврийн хэрэгсэл гэх мэт/, эд хогшил, техник хэрэгсэлд урсгал засвар хийхтэй холбогдон гарсан зардал /засвар үйлчилгээний материал авах, засвар үйлчилгээний хөлс гэх мэт/ -ыг энэ дансанд бүртгэнэ. Харин их засварын зардлыг энд бүртгэхгүй.[1]

2 1 1 1 3 17 Эдийн засгийн арга хэмжээ. Төр засгаас улс орны эдийн засгийг хөгжүүлэх, өсөлтийг хангах бодлогын дагуу хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээний зардлыг энд бүртгэнэ. Эдийн засгийн арга хэмжээний зардлыг 1/ бөөний худалдааны сүлжээ зохион байгуулах, 2/ эдийн засгийн бодлого, стратеги судалгааны арга хэмжээний зардал гэж ангилан төлөвлөлт, гүйцэтгэлийг тооцно.

2 1 1 1 3 18 Урлаг, соёл, спортын арга хэмжээ. Төсөвт байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд урлаг, соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах, оролцохтой холбогдсон урсгал зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Энэ зардлыг 1/ биеийн тамирын уралдаан, тэмцээн, 2/ соёл урлаг хөгжүүлэх, 3/ түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, 4/ музейн үзмэр авах зардал гэж ялган төлөвлөлт, гүйцэтгэлийг гаргана.

2 1 1 1 3 19 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ. Орон нутгийн засаг захиргааны үүргийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн нутаг дэвсгэрт зохион байгуулахтай холбогдсон зардлыг энд бүртгэнэ. Хуулиар хүлээсэн үндсэн үүрэг нь гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа болсон цагдаагийн зэрэг байгууллагуудын хувьд энэ ангилал хамаарахгүй.

2 1 1 1 3 20 Байгаль орчин, газар, хот тохижилтын арга хэмжээ. Байгаль орчныг хамгаалах, байгалийн хөнөөлт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, газар арчлах болон газрын бүртгэл, эрхийн асуудалтай холбогдсон зардал болон хот тохижуулалт, цэвэрлэгээ зэрэг ажлыг зохион байгуулахтай холбогдсон зардлыг энд бүртгэнэ. Үүнийг 1/ газрын зургийн зардал, 2/ гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, 3/ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, 4/ ургамал хамгааллын зардал, 5/ газрын хянан баталгааны зардал, 6/ хог хаягдал устгах, цэвэрлэх гэж тус бүрээр төлөвлөлт, гүйцэтгэлийг гаргана.

2 1 1 1 3 21 Орон нутгийн нөөц хөрөнгө. Орон нутгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд зарцуулагдах нөөц хөрөнгийг энэ ангилалд бүртгэн, төлөвлөлт, гүйцэтгэлийг хуулийн дагуу зарцуулагдах зориулалтаар гаргана.

2 1 1 1 3 22 Орон нутгийн хуваарилагдаагүй зардал. Орон нутгийн засаг захиргааны хариуцан эрхэлж, тухайн нутаг дэвсгэрт төрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах бөгөөд төсөвт харьяалагдах урсгал зардлуудыг энд бүртгэнэ. Үүнд 1/ баяр наадмын зардал, 2/ маягт хэвлэх зардал, 3/ бусад нэр төрлийн хуваарилагдаагүй гэсэн зардлын ангилал багтах бөгөөд эдгээрийг тус бүрээр нь төлөвлөн, гүйцэтгэлийг тайлагнана.

2 1 1 1 3 23 Сонгуулийн зардал. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүдийг сонгох сонгуулийн ажиллагааг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг энд бүртгэнэ. Сонгуулийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага (Сонгуулийн ерөнхий хороо)-ын зардлыг энд тусгахгүй.

2 1 1 1 3 24 Мал, хөдөө аж ахуйн арга хэмжээ. Малын удмын санг хамгаалах, мал аж ахуйн үржлийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйл ажиллагааг дэмжих зэрэг арга хэмжээг зохион байгуулахтай холбогдон гарах зардлуудыг энэ ангилалд бүртгэнэ. Үүнд 1/ ногоон хувьсгал хөтөлбөрийн зардал, 2/ мал аж ахуйн үржлийн зардал багтана.

2 1 1 1 3 25 Мэдээлэл сурталчилгааны арга хэмжээ. Улс орныг сурталчлах, төрийн ажил,

объект, тоног төхөөрөмж зэргийг зах зээлээс худалдан авах буюу төрийн эзэмшилд үйлдвэрлэн бүтээн бий болгох төсөл, арга хэмжээнд зарцуулах зардлыг төсвөөс санхүүжүүлэх үед энэ ангилалд бүртгэнэ. Дотоод хөрөнгө оруулалтыг эх үүсвэрээр нь ангилан бүртгэнэ.

2 1 2 2 Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх. Засгийн газрын тогтоол, шийдвэрээр стратегийн болон онцгой нөхцөл байдлын зориулалтаар улсын нөөцөд хүнс, бараа, материал нөөцлөхөд зарцуулахад гарсан зардлыг энэ ангилалд бүртгэнэ.

2 1 2 3 Газар ба материаллаг бус зүйлийн зардал. Газар, ой, хөрсний баялаг гэх мэт хөрөнгө болон өмч хөрөнгө бүртгэгдэх эрхийн зөвшөөрөл мэтийн материаллаг бус зүйлсийг өмчлөх зорилгоор худалдан авахад зарцуулах хөрөнгийг энд бүртгэнэ.

2 1 2 4 Хөрөнгийн шилжүүлэг. Хүлээн авагч үл хөдлөх хөрөнгө худалдан авах, их засвар оруулах зэрэг төсвөөс шилжүүлсэн хөрөнгийн шинж чанартай шилжүүлгийг энд бүртгэнэ.

2 1 2 5 Гадаад зээлээс санхүүжих хөрөнгө оруулалт. Хоёр талын болон олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу гадаад зээлээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлыг энэ ангилалд бүртгэнэ.

2 1 3 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл. Засгийн газраас бусад этгээдэд олгосон зээл, Засгийн газраас хувийн хэвшлээс худалдан авсан хувьцаа, үнэт цаасны зардлын нийлбэрээс зээлийн эргэн төлөлт, хувьцаа, үнэт цаасны худалдааны орлогыг хассан дүнг энд бүртгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

**2009 оны 06 дугаар сарын 15-ны өдөр** — **Дугаар 19** — **Улаанбаатар хот**

### Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь хэсгийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ нь:**

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т заасан "... **бүртгүүлэх үед ...**" гэдэгт мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх тухай өргөдлийг татварын албанд гаргасан өдрөөс энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д зааснаар татварын албанаас нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэж, гэрчилгээ олгосон өдөр хүртэлх хугацаа хамаарна.

2. Мөн зүйл, хэсэгт заасан "... **нэмэгдсэн өртгийн албан татвартай нь хамт худалдан авсан** ..." гэдэгт бүртгүүлэх өргөдөл гаргагч нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч этгээдээс дээрх хугацаанд худалдаж авсан бараа, ажил үйлчилгээг хамааруулж үзнэ.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР**

**ШҮҮГЧ Д.ПУНЦАГ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон-128 тоот
и-мэйл: turiin_medeelel@parliament.mn

☎ 262420, 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 3.5